



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/009/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalq@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн захирал: М.Буянбулган Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalqaattaudit.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-02-25 № 289
танай _____-ны № _____-г

НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР
ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЭНХТӨР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоос 736.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 706.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 95.9 хувиар биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Аж ахуй нэгж, байгууллагаас авах нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын үлдэгдэл өмнөх оноос 35.0 хувиар буюу 26.0 тэрбум төгрөгөөр өсч 100.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнд, нэг жилээс дээш насжилттай 1,561 харилцагчийн авлага байгаа нь нийт авлагын үлдэгдэлд 14.0 хувийг эзэлж байна.

Шалгагдагч байгууллагаас олон жилийн насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээ авч, холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлж, нийгмийн

C:\Users\naranguu\Desktop\Биеийн хэргийн 2026-02-25\audit\main\2025-02-25 Dugnell-0001

даатгалын шимтгэлийг барагдуулах шийдвэр гарсан боловч барагдуулалт удаашралтай, мөн зарим аж ахуйн нэгж, байгууллагатай авлага барагдуулах гэрээ байгуулсан боловч хуваарийн дагуу шимтгэлийг бүрэн шилжүүлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус нийгмийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд "SICOS" системийг ашиглаж байна. Уг системээс аудитын явцад ашиглах ерөнхий мэдээллийг авч ашигласан боловч ажил гүйлгээний тоо хэмжээний хязгаартайгаар ерөнхий журнал системээс хөрвүүлэлт хийгддэг бөгөөд эдгээр мэдээлэлд боловсруулалт хийж, ашиглахад хүндрэлтэй байв.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	122,104,589,427.86	141,531,599,434.39
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	17,358,753,198.73	10,799,339,740.29
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	17,358,753,198.73	10,799,339,740.29
31213	Арилжааны банк дахь харилцах	17,358,753,198.73	10,799,339,740.29
33	АВЛАГА	104,745,836,229.13	130,732,259,694.10
33300	Татаас, санхүүжилтийн авлага	29,332,967,467.70	29,325,776,052.70
33402	Татвар, НДШ-н авлага	74,595,876,301.17	100,612,407,896.41
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
335	Бусад авлага	816,992,460.26	794,075,744.99
33510	Байгууллагаас авах авлага	336,237,242.05	257,766,074.20
33520	Хувь хүмүүсээс авах авлага	480,755,218.21	536,309,670.79
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	122,104,589,427.86	141,531,599,434.39
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	5,701,940,631.55	8,517,102,033.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,701,940,631.55	8,517,102,033.01
413	Өглөг	1,072,147,943.19	4,036,336,779.96
4136	Бусад өглөг	1,072,147,943.19	4,036,336,779.96
41361	Байгууллагад төлөх өглөг	313,860.00	16,612,644.70
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	969,723,922.39	3,981,841,405.96
41366	Дансны өглөг	102,110,160.80	37,882,729.30
414	Урьдчилж олсон орлого	4,629,792,688.36	4,480,765,253.05
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	4,629,792,688.36	4,480,765,253.05
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	116,402,648,796.31	133,014,497,401.38
51	Засгийн газрын хувь оролцоо	116,402,648,796.31	133,014,497,401.38
512	Хуримтлагдсан үр дүн	116,402,648,796.31	133,014,497,401.38
51210	Өмнөх үеийн үр дүн	116,402,648,796.31	115,363,397,318.93
51220	Тайлант үеийн үр дүн	-	17,651,100,082.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	122,104,589,427.86	141,531,599,434.39

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	903,600,751,622.57	1,038,106,129,858.41
11	ТАТВАРЫН ОРЛОГО	634,851,339,815.52	731,306,685,435.80
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	634,851,339,815.52	731,306,685,435.80
112	Тэтгэврийн даатгалын шимтгэл	528,663,315,401.41	608,873,585,995.77
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	528,663,315,401.41	608,873,585,995.77
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	56,066,524,162.38	65,153,629,832.40
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	29,756,826,536.73	33,804,239,845.77
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	20,364,673,715.00	23,475,229,761.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	769,344,438.97	306,799,444,422.61

120	Нийтлэг татварын бус орлого	769,344,438.97	925,400,353.61
120002	Хүүгийн орлого	240,104,897.72	205,619,082.72
120003	Торгуулийн орлого	52,542,000.00	90,363,900.00
120009	Бусад орлого	476,697,541.25	629,417,370.89
122	Тусламжийн орлого	-	305,874,044,069.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	305,874,044,069.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	91,329,707,385.00
122152	НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\	-	91,329,707,385.00
122004	НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого	-	214,544,336,684.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	267,980,067,368.08	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	74,292,301,618.08	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	74,292,301,618.08	-
1330	Төсвийн захирагчдаас	193,687,765,750.00	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	193,687,765,750.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	890,688,126,986.05	1,020,455,029,775.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	890,688,126,986.05	1,020,455,029,775.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,587,189.99	25,199,231.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	25,587,189.99	25,199,231.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,385,269.99	11,166,681.10
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	13,201,920.00	14,032,550.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	890,662,539,796.06	1,020,429,830,544.86
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	711,462,168,131.37
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	711,462,168,131.37
213104	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	711,462,168,131.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	269,676,863,638.99	308,967,662,413.49
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	269,676,863,638.99	308,967,662,413.49
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	620,985,676,157.07	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	620,985,676,157.07	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12,912,624,636.52	17,651,100,082.45
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	12,912,624,636.52	17,651,100,082.45

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,003,369,278,632.20	1,147,023,145,590.41
11	ТАТВАРЫН ОРЛОГО	736,354,429,493.92	706,061,615,843.57
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	736,354,429,493.92	706,061,615,843.57
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	508,604,181,721.85	587,996,726,545.71
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	54,382,175,835.35	62,869,932,153.07
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	37,950,953,334.32	32,588,642,579.10
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	20,738,548,024.13	22,606,314,565.69

112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	114,678,570,578.27	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,235,137,988.28	440,961,529,746.84
120	Нийтлэг татварын бус орлого	1,235,137,988.28	135,080,294,262.84
1201	Хүүгийн орлого	1,235,137,988.28	135,080,294,262.84
120002	Бусад хүүгийн орлого	243,967,111.87	206,570,765.76
120009	Бусад орлого	991,170,876.41	134,873,723,497.08
122	Тусламжийн орлого	-	305,881,235,484.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	305,881,235,484.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	91,336,898,800.00
122152	НДС-д УТ-с олгох татаасын орлого (\УТ-НДС\)	-	91,336,898,800.00
122004	НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого	-	214,544,336,684.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	265,779,711,150.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	72,091,945,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	72,091,945,400.00	
1330	Төсвийн захирагчдаас	193,687,765,750.00	-
133002	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвтбайгууллага/	193,687,765,750.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,006,729,553,635.36	1,153,582,559,048.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,006,729,553,635.36	1,153,582,559,048.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	505,713,943.40	644,282,344.63
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,587,189.99	25,199,231.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,385,269.99	11,166,681.10
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	13,201,920.00	14,032,550.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	480,126,753.41	619,083,113.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	480,126,753.41	619,083,113.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,006,223,839,691.96	1,152,938,276,704.22
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	846,978,771,584.96
21311	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	846,978,771,584.96
213104	НДС-н орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	846,978,771,584.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	269,261,350,435.10	305,959,505,119.26
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	269,261,350,435.10	305,959,505,119.26
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	736,962,489,256.86	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	736,962,489,256.86	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(3,360,275,003.16)	(6,559,413,458.44)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(3,360,275,003.16)	(6,559,413,458.44)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,719,028,201.89	17,358,753,198.73
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,358,753,198.73	10,799,339,740.29

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

<i>/төгрөгөөр/</i>					
№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	113,123,519,285.01	113,123,519,285.01
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(9,633,495,125.22)	(9,633,495,125.22)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	103,490,024,159.79	103,490,024,159.79
4	Тайлант үеийн үр дүн	-	-	12,912,624,636.52	12,912,624,636.52
5	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	116,402,648,796.31	116,402,648,796.31
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,039,251,477.38)	(1,039,251,477.38)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	115,363,397,318.93	115,363,397,318.93
8	Тайлант үеийн үр дүн	-	-	17,651,100,082.45	17,651,100,082.45
9	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	133,014,497,401.38	133,014,497,401.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

<i>/төгрөгөөр/</i>					
Код	Дансны нэр төрөл	1.Төлөвлөгөө	2.Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛ СЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	827,790,980,000.00	798,013,610,135.06	29,777,369,864.94	96.4%
11	Татварын орлого	736,454,081,200.00	706,676,711,335.06	29,777,369,864.94	96.0%
112	Нийгмийн даатгалын орлого	736,454,081,200.00	706,676,711,335.06	29,777,369,864.94	96.0%
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	626,331,008,800.00	588,506,538,315.04	37,824,470,484.96	94.0%
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	56,752,301,400.00	62,934,322,539.40	-6,182,021,139.40	110.9%
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	29,835,144,700.00	32,595,102,731.74	-2,759,958,031.74	109.3%
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	23,535,626,300.00	22,640,747,748.88	894,878,551.12	96.2%
12	Татварын бус орлого	91,336,898,800.00	91,336,898,800.00	0.00	100.0%
122	Тусламжийн орлого	91,336,898,800.00	91,336,898,800.00	0.00	100.0%
122001	Хандив тусламж /дотоод/	91,336,898,800.00	91,336,898,800.00	0.00	100.0%

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	305,852,606,600.00	305,984,704,350.36	-132,097,750.36	100.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	305,852,606,600.00	305,984,704,350.36	-132,097,750.36	100.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,881,700.00	25,199,231.10	11,682,468.90	68.3%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,881,700.00	25,199,231.10	11,682,468.90	68.3%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,397,400.00	11,166,681.10	230,718.90	98.0%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	25,484,300.00	14,032,550.00	11,451,750.00	55.1%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	305,815,724,900.00	305,959,505,119.26	-143,780,219.26	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	305,815,724,900.00	305,959,505,119.26	-143,780,219.26	100.0%
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	305,815,724,900.00	305,959,505,119.26	-143,780,219.26	100.0%
8	ТЭНЦВЭРЖҮҮЛ СЭН НИЙТ ТЭНЦЭЛ	521,938,373,400.00	492,028,905,784.70	29,909,467,615.30	94.3%
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	521,938,373,400.00	492,028,905,784.70	-29,909,467,615.30	94.3%
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	521,938,373,400.00	492,028,905,784.70	-29,909,467,615.30	94.3%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	17,358,753,198.73	-17,358,753,198.73	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	10,799,339,740.29	-10,799,339,740.29	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 972,243.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 859,114.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 3 зөвлөмж өгөв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс			
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын үлдэгдлийг санхүүгийн тайлан бэлтгэх өдрийн байдлаар баримтжуулаагүй	1	801,948.4	-	-	1	801,948.4	-	-
2	Эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага, өглөг бүртгэлтэй байна	1	57,165.8	-	-	1	57,165.8	-	-
3	Ирүүлсэн санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийн эхний үлдэгдэлийн дүн гүйлгээ балансын эхний үлдэгдлийн дүнгээс зөрүүтэй илэрхийлэгдсэн.	1	14,848.8	-	-	-	-	1	14,848.8
4	Тайлант оны эхний үлдэгдлээс буураагүй, цаашид найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулах ажил зохион байгуулаагүй.	1	88,286.9	-	-	-	-	1	88,286.9
5	НДШ-ын авлагын насжилтын тайланг зөрүүтэй илэрхийлсэн.	1	9,993.6	-	-	-	-	1	9,993.6
	Дүн	5	972,243.5	-	-	2	859,114.2	3	113,129.3

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ЗГТС	1	1			1			
	НИЙТ	1	1			1			